



ШИВЭЭ ОВОО

“ШИВЭЭ-ОВОО”  
ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2016 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

Зээл авах зөвшөөрөл  
олгох тухай

Компанийн тухай хуулийн 76.1.18, “Шивээ Овоо” ХК-ийн дүрмийн 11.10, Гүйцэтгэх захиралтай байгуулсан “Хөлсөөр ажиллах гэрээ”-ний 3.7 дугаар заалт, болон Гүйцэтгэх удирдлагын саналыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Шивээ Овоо” ХК-ийн 2015 оны хувьцаа эзэмшигчдийн хурлын 01 дугаар тогтоолоор батлагдсан Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд Гүйцэтгэх захиралын 2016 оны 01 сард байгуулсан ШО-16-16 тоот “Автосамосвал нийлүүлэх тендерийн гэрээ”-ний урьдчилгаа төлбөрийг санхүүжүүлэх зорилгоор арилжааны банкнаас 2,4 тэрбум төгрөгийн зээлийг сарын 1,7-оос дээшгүй хувийн хүүтэй, нийт 18 сарын хугацаатай авахыг Гүйцэтгэх захирал (О.Отгонбаатар)-д зөвшөөрсүгэй.

2. Тус зээлийн баталгаанд нүүрсний зарим авлага болон “ДЦС-4” ТӨХК-аас төлөгдөх борлуулалтын орлогыг барьцаалахыг Гүйцэтгэх захирал (О.Отгонбаатар)-д зөвшөөрсүгэй.

3. Зээлийн зарцуулалтын тайланг 1 сарын дотор Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулахыг Гүйцэтгэх захирал (О.Отгонбаатар)-т үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.БЯМБАСАЙХАН